



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/284

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6.-ийн "г", Захиргааны ерөнхий хуулийн 40.2.4 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны ээлжит IX дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн өргөдөл хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 26 -ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрээр эрүүл мэнд болон амьдралын аргагүй байдлыг нь харгалзан үзэж Мөрөн сумын иргэнд Н.Нямсүрэнд 300,000 төгрөг, Р.Лхамжавд 100,000 төгрөг, Ц.Ганзоригт, Л.Нацагням, Ц.Отгонбаяр Ж.Чулуунцэцэг нарт тус бүрт нь 50,000 төгрөгийн тусламж, дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД